

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.06.30**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- АНУ-БНХАУ Женевт худалдааны гол асуудлаар тохиролцсоны дараа Хятадын CSI 300 индекс 1.95%, Шанхай Композит 1.91%, Хан Сенг 3.2% өсөв.
- АНУ-ын Худалдааны сайд Ховард Латник хоёр орны худалдааны ойлголцлын үндсэн бүтэцтэй холбоотой мэдэгдэл хийж, зах зээлд түр тогтворжилт авчрав.
- Hang Seng индекс Head and Shoulders Bottom хээ баталгаажуулснаар ханш 25,500–28,000 бүс рүү чиглэх боломж нээгдсэн байна.
- АНУ-ын S&P 500 индекс 3.44%, Nasdaq 4.25% өсч, шинэ дээд түвшинд хүрч хаагдав.
- PCE үнийн индексийн үндсэн инфляц жилийн дүнгээр 2.7%-д хүрч, зах зээлийн хүлээлтээс өндөр гарсан нь эдийн засгийн сорилтыг нэмэгдүүллээ.
- Мичиганы судалгаагаар хэрэглэгчдийн инфляцын хүлээлт 6.6%-иас 5%-д огцом буурч, хэрэглэгчдийн итгэл 16%-иар өссөн нь зах зээлд эерэг хандлага төрүүлэв.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>

VIX индекс 20 нэгжээс доош нэвтэрсэн ба VVIX индекс хэлбэлзлийнхээ хамгийн доод бүсэд буй нь VIX futures авч АНУ-ын хувьцааны багцдаа хедж хийх тохиромжтой үе ирснийг илтгэнэ. Үүний тулд \$VXX, \$UVXY зэрэг VIX ETF эсвэл VX (CBOE VIX futures) фьючерсийг ашиглаж болно.

### VIX



### VVIX





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.06.23-06.27

## ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД ШИНЭ ДЭЭД ТҮВШИНДЭЭ ХҮРЛЭЭ

АНУ-ын хувьцааны гол индексүүд өнгөрсөн долоо хоногт огцом өсч, S&P 500 болон Nasdaq Composite шинэ дээд түвшиндээ хүрч хаагдлаа. S&P 500 индекс 3.44%, Nasdaq 4.25% өссөн бол Dow Jones, S&P MidCap 400, Russell 2000 индексүүд 2.5%-иас дээш өсөлт үзүүлэв.

Өсөлтийн гол шалтгаанууд:

- Ойрхи Дорнодын хурцадмал байдал намжсан
- Холбооны Нөөцийн Сангийн (Fed) зарим албан тушаалтнууд мөнгөний бодлогын хувьд зөөлөн байр суурь илэрхийлсэн
- АНУ-БНХАУ-ын худалдааны шинэ гэрээ байгуулагдсан мэдээ гарсан
- Бусад худалдааны гэрээнүүд дуусах шатандаа орсон тухай мэдээлэл цацагдсан

## БОДИТООР ИНФЛЯЦ ӨСӨЖ БҮЙ Ч ХҮЛЭЭЛТ НЬ БАГАСЛАА

Холбооны Нөөцийн Сангийн инфляцыг хэмжих гол үзүүлэлт болох PCE үнийн индексээр үндсэн инфляц 5-р сард сарын дүнгээр 0.2%, жилийн дүнгээр 2.7% болж, өмнөх сараас (0.1%, 2.6%) өсч, зах зээлийн хүлээлтээс өндөр гарлаа.

Инфляц бодитоор өндөр гарч буй хэдий ч Мичиганы Их Сургуулийн судалгаагаар хэрэглэгчдийн инфляцын хүлээлт 6.6%-иас 5%-д огцом багасч, хэрэглэгчдийн сентимент индекс 16%-иар өсч 60.7-д хүрсэн нь хүмүүсийн итгэл сэргэж байгааг илтгэв.

S&P 500 индекс урт хугацаанд өсөлтийн чиглэлд шилжээд байна. Гэхдээ хэрэв ханш 6110 түвшинг доош нэвтэлбэл урт хугацааны өсөлтийн төлөв хүчингүй болох эрсдэлтэй. Иймд зорилтот ханшийг 6680 орчимд, алдагдлыг хязгаарлах стоплоссыг 6110 түвшинд тохируулах нь оновчтой юм.

Golomt\_Capital created with TradingView.com, Jun 30, 2025 10:23 UTC+8

S&P 500 E-mini Futures - 1W - CME O6,223.25 H6,245.00 L6,223.25 C6,243.75 +23.00 (+0.37%) -23.00 (+0.37%)  
SMA (40, close) 5,879.72







## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.06.16 – 06.22

### ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ОГЦОМ ӨСӨВ

АНУ болон БНХАУ хоёр өнгөрсөн сард Женев хотод хийсэн хэлэлцээрээр худалдааны асуудлаар үндсэн ойлголцолд хүрч, албан ёсоор тохиролцсон нь Хятадын хөрөнгийн зах зээлд эрчимтэй өсөлтийг авчирлаа. Тухайлбал, эх газрын гол индексүүд болох CSI 300 индекс 1.95%-иар, Шанхай Композит индекс 1.91%-иар өссөн талаар FactSet мэдээлсэн байна. Түүнчлэн, Хонконгийн Хан Сенг индекс илүү хурдтай буюу 3.2%-ийн өсөлт үзүүлж, зах зээлд эерэг уур амьсгал бүрдсэн юм.

### ХЯТАД БА АНУ-ЫН ХУДАЛДААНЫ ХАРИЛЦАА ТҮР ТОГТВОРЖЛОО

АНУ-ын Худалдааны сайд Ховард Латник өнгөрсөн пүрэв гарагт хоёр улсын худалдааны харилцааг зохицуулах үндсэн зарчмуудыг танилцууллаа. Ховард Латник хоёр улсын худалдааны ойлголцлын үндсэн бүтэцтэй холбоотой албан ёсны мэдэгдэл хийснээр АНУ, БНХАУ-ын харилцаа түр хугацаанд тогтворжих шинжтэй болов. Үүний дараах баасан гарагт Бээжин энэхүү тохиролцооны зарим заалтыг баталж, 2025 оны турш яригдсан хэлэлцээрийн гол агуулгыг хуульчилсан гэж үзжээ. Тухайлбал, Хятад улс ховор металлын нийлүүлэлтийг тогтвортой байлгахаа дахин амласан юм. Гэсэн ч одоогоор дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирээгүй бөгөөд фентанилын хууль бус наймаатай холбоотой асуудал шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.


















































Hang Seng индекс Head and Shoulders Bottom хээ бүрдүүлж, өсөлтийн хандлага баталгаажлаа. Одоогийн ханш 24,148 орчимд байгаагаас харахад 25,500–28,000 бүс рүү чиглэх боломж өндөр байна. RSI өсөлт дэмжиж, зах зээл хэт худалдан авалтын бүсэд ороогүй байна. Харин 19,400 түвшингийн доор хаалт өгвөл өсөлтийн төсөөлөл хүчтэй сулрах эрсдэлтэй.

Golomt\_Capital created with TradingView.com, Jun 30, 2025 10:40 UTC+8
















Hang Seng Index - 1M · HSI 023,043.10 H24,533.39 L22,668.35 C24,147.88 +858.11 (+3.68%) -136.27 (-0.56%)  
SMA (40, close) 19,437.95



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 23, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 CMC	 KBH	 CCL	 FDX	 GIS	 MU	 AYI	 NIKE	 APOG	 entropix inc.
 FDS	 kb HOME	 CARNIVAL CORPORATION & P&C	 BB	 PAYX	 JEFF	 WBA	 CNXC		
 FACTSET		 TD SYNEX	 BlackBerry	 PAYCHEX	 Jefferies	 Wagman Bates Alliance	 CONCENTRIX		
		 WOR	 WORTHINGTON	 DART	 WS	 LNN	 ACUT		
		 AVAV	 AeroVironment	 DAKTRONICS	 FBL	 LINDSAY	 AMERICAN		
		 ATEX	 Anterix	 WINNEBAGO	 H.B. Fuller	 MCC	 EPAC		
				 NOVAGOLD	 SCS	 McConnell	 ENERPAC		
					 Steelcase	 HIVE	 TOOL GROUP		
					 MLKN	 ORION			
					 MillerKnoll				
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2025 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 30, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
	 PRGS	 MSC	 STZ	 UNF	 FC				
	 Progress	 Constellation Brands		 UniFirst	 FranklinCovey				
	 QIMCO	 GBX	 THE GREENBRIER COMPANIES	 ZENV	 zenvia				
	 Quantum								
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2025 Earnings Whispers	